

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-63-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">ИНД-63 - Нисэх Инженерийн Үнэмлэх, Зэрэглэл (Шинэчлэгдэж байгаа) / 19 хуудас/ 2006 оны NZ amend.2</p>	<p align="center">ИНД-63 - Нисгэгчээс Бусад Нисэх Багийн Гишүүний Үнэмлэх, Зэрэглэл (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /20 хуудас (үндсэн дүрэм- 29 хуудастай байсан)/ 2006 оны NZ original_issue</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>63.1 Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) сурагч-нисэх инженерийн үнэмлэх болон нисэх инженерийн үнэмлэх, зэрэглэл олгох;</p> <p>(2) тухайн үнэмлэх, зэрэглэл шаардлагатай нөхцөл;</p> <p>(3) тухайн үнэмлэх, зэрэглэлийн эрх, хязгаарлалт;</p>	<p>63.1. Зорилго (а) Энэхүү дүрмийн зорилго нь дараах зүйлсэд тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино:</p> <p>1/ сурагч-нисэх инженерийн үнэмлэх, нисэх инженерийн үнэмлэх, <u>нисэн хянагч болон агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх</u>, нисэх инженерийн зэрэглэл олгох;</p> <p>2/ дээрх үнэмлэх, зэрэглэл авахад шаардагдах нөхцөл;</p> <p>3/ дээрх үнэмлэх, зэрэглэлийн хүрээнд эдлэх эрх, үүргийн хязгаарлалт.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.3 Үнэмлэх, зэрэглэлийн шаардлага</p> <p>(а) <u>Монгол Улс дотор, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх этгээд нь дараах үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй:</u></p> <p>(1) энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн хүчинтэй үнэмлэх; эсхүл</p> <p>(2) Даргын хүлээн зөвшөөрсөн, гадаадын <u>сурагч-нисэх инженерийн</u>, эсхүл нисэх инженерийн хүчинтэй үнэмлэх.</p> <p>(б) Гадаад улсад, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх этгээд нь дараах үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй.</p> <p>(1) энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн хүчинтэй үнэмлэх; эсхүл</p> <p>(2) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа улсаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн хүчинтэй үнэмлэх.</p> <p>(с) <u>Монгол Улс дотор, гадаадын бүртгэлтэй агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх этгээд нь дараах үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй:</u></p>	<p>63.3. Үнэмлэх, зэрэглэлд тавигдах шаардлага</p> <p>(а) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг дээр нисэх инженер болон нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь:</p> <p>1/ энэ дүрмийн дагуу олгогдсон сурагч-нисэх инженер, эсхүл сурагч-нисэн хянагчийн эсхүл нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; эсхүл</p> <p>2/ гадаадын эрх бүхий байгууллагаас олгогдсон нисэх инженер <u>эсхүл нисэн хянагчийн</u> хүчин төгөлдөр үнэмлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргаар хүлээн зөвшөөрүүлсэн байх.</p> <p><u>(б) Агаарын хөлгийн диспатчер нь энэ дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр үнэмлэхтэй байна.</u></p> <p>(в) Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэх этгээд нь:</p> <p>1/ энэ дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; эсхүл</p> <p>2/ гадаадын эрх бүхий байгууллагаас олгогдсон нисэх инженер, эсхүл <u>нисэн хянагчийн хүчин</u> төгөлдөр үнэмлэхийг ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрүүлсэн байх.</p>	<p>-Монгол улсад, гадаадын бүртгэлтэй агаарын хөлөгт нисэх инженерийн эзэмших үнэмлэхний үүргийг нэмж өгсөн.</p>

<p>(1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх; эсхүл</p> <p>(2) Даргын хүлээн зөвшөөрсөн хүчинтэй гадаадын сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх; эсхүл</p> <p>(3) тухайн агаарын хөлгийг Бүртгэгч улсаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн хүчинтэй сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх.</p> <p>(d) Монгол Улс дотор, Монгол улсын, эсхүл гадаадын бүртгэлтэй агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх, сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчээс бусад этгээд нь тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p> <p>(e) 63.305(а)-д заасан багш-нисэх инженерийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, хүчинтэй багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p> <p>(f) 63.355(а)-д заасан шалгагч-нисэх инженерийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, хүчинтэй шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p>	<p style="text-align: center;"><u>2002 онд орхигдуулсан</u></p> <p>(г) Монгол Улсад, эсхүл гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх (сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчээс бусад) нисэх инженер нь тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй байна.</p> <p>(д) Энэ дүрмийн дагуу багш-нисэх инженер, эсхүл багш-нисэн хянагчийн эрх эдлэх этгээд нь энэ дүрмийн дагуу олгогдсон багшлах эрх олгосон хүчин төгөлдөр зэрэглэлтэй байна.</p> <p>(ж) Энэ дүрмийн дагуу шалгагч-нисэх инженер, эсхүл шалгах-нисэн хянагчийн эрх эдлэх этгээд нь энэ дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр шалгах зэрэглэлтэй байна.</p>	<p>-2002 онд орхигдуулсан</p>
<p>63.5 Үнэмлэх, зэрэглэл</p> <p>(а) Энэ Дүрмийн дагуу дараах үнэмлэх болон зэрэглэл олгоно:</p> <p>(1) Сурагч-нисэх инженерийн үнэмлэх;</p> <p>(2) Нисэх инженерийн үнэмлэх;</p> <p>(3) Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл;</p> <p>(4) Нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл;</p> <p>(5) Багш-нисэх инженерийн зэрэглэл;</p> <p>(6) Шалгагч-нисэх инженерийн зэрэглэл.</p> <p>(b) Багш-нисэх инженерийн болон шалгагч-нисэх инженерийн зэрэглэлийг нисэх инженерийн үнэмлэхэнд тэмдэглэсэн байна. Бусад бүх зэрэглэлийг нисэх инженерийн нисгэгчийн дэвтэрт тэмдэглэх ба нисэх инженерийн үнэмлэхэнд нэмж тэмдэглэж болно</p>	<p>63.5. Үнэмлэх ба зэрэглэл</p> <p>(а) Энэ дүрмээр дараах ангиллын үнэмлэх олгож, зэрэглэл тогтооно:</p> <p>1/ сурагч-нисэх инженерийн үнэмлэх;</p> <p>2/ нисэх инженерийн үнэмлэх;</p> <p>3/ нисэн хянагчийн үнэмлэх</p> <p>4/ агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх</p> <p>5/ нислэгийн радио холбооны операторын зэрэглэл;</p> <p>6/ нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл;</p> <p>7/ багш-нисэх инженерийн зэрэглэл;</p> <p>8/ багш-нисэн хянагчийн зэрэглэл</p> <p>9/ шалгах-нисэх инженерийн зэрэглэл</p> <p>10/ шалгах-нисэн хянагчийн зэрэглэл.</p> <p>(б) Нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн багшлах, шалгах зэрэглэлийг үнэмлэхэнд, бусад зэрэглэлийг нислэгийн дэвтэрт тэмдэглэх бөгөөд нэмэлт болгон үнэмлэхэнд тэмдэглүүлж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.7 Хугацаатай үнэмлэхийг хугацаагүй үнэмлэхээр солих</p> <p>(а) ИНД-63-ын дагуу өмнө олгосон сурагч-нисэх инженерийн болон нисэх инженерийн үнэмлэхийг энэ Дүрмийн дагуу олгосонд тооцох ба шалгалт, эсхүл тест авахгүйгээр шинэ үнэмлэхээр сольж болно.</p>	<p>63.7. Нөөц</p> <p style="text-align: center;"><u>2002 онд орхигдуулсан</u></p>	<p>-2002 онд орхигдуулсан хэсгийг нэмж оруулсан</p>

<p><u>(b) ИНД-63-ын дагуу өмнө олгосон үнэмлэхний зэрэглэл нь энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэхэнд шилжих ба энэ Дүрмийн дагуу олгосонд тооцогдоно.</u></p>		
<p>63.9 Үнэмлэх, зэрэглэл эзэмших хүсэлт гаргах Сурагч-нисэх инженерийн, нисэх инженерийн үнэмлэх, багш-нисэх инженерийн, эсхүл шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь CAA 24061/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.</p>	<p>63.9. Өргөдөл гаргах (a) Энэ дүрмийн 63.5–д заасан үнэмлэх, зэрэглэлийг авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-063/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.11 Үнэмлэх, зэрэглэл олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн дагуу Даргын олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших эрхтэй: (1) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх; (2) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигчийн хувьд, үүрэг хариуцлагаа зохих ёсоор гүйцэтгэхийн тулд тухайн байгууллагын ерөнхий заавар болон нислэгийн заавар бичигдсэн хэлээр унших, ярих болон ойлгох чадвартай байх; (3) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хамаарах Бүлэгт заасан бүх нөхцөл хангах шаардлагыг хангасан байх; (4) тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>63.11. Үнэмлэх, зэрэглэл олгох (a) Дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид энэ дүрмийн дагуу ИНЕГ-ын дарга үнэмлэх, зэрэглэл олгоно: 1/ өргөдөл гаргагч нь “тохирох зөв хүн” /fit and proper/-д тавигдах шаардлагыг хангасан байх; 2/ өргөдөл гаргагч нь үнэмлэх, зэрэглэлээр олгогдох эрхээ эдэлж, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байхын тулд англи, монгол хэлээр унших, ярих, ойлгох, харилцах чадвартай байх; 3/ өргөдөл гаргагч нь үнэмлэх, зэрэглэлтэй холбогдох бүлгүүдэд тавигдсан шаардлагыг хангасан байх; 4/ тухайн үнэмлэх, зэрэглэлийг олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.</p>	<p>-Зөвхөн англи монгол хэлийг заалгүй шаардлагатай гадаад хэл гэж зааж өгсөн</p>
<p>63.13 Үнэмлэх, зэрэглэлийн хугацаа (a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хуулийн дагуу хүчингүй болгосон, эсхүл түдгэлзүүлээгүй бол, энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэл нь тухайн эзэмшигчийн насан туршид хүчинтэй байна. (b) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түр үнэмлэх, эсхүл зэрэглэл олгож болно.</p>	<p>63.13. Үнэмлэх, зэрэглэлийн хугацаа (a) Энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд, энэ дүрмээр олгогдсон үнэмлэх, зэрэглэл, насан туршид нь хүчин төгөлдөр байна. (б) Агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэхийг 2 жилийн хугацаатай олгоно. (в) ИНЕГ-ын дарга үнэмлэх, зэрэглэлийн үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгож болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл түр үнэмлэх, түр зэрэглэл олгож болно.</p>	<p>-Агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх гэсэн хэсгийг хассан</p>
<p>63.15 Шалгалт (a) Энэ Дүрмийн дагуу бичгийн шалгалт өгөх этгээд нь: (1) өөрийгөө нотлох баримт бичгийг биедээ авч явах; (2) тухайн шалгалтад тэнцэхийн тулд боломжит үнэлгээний 70%-иас доошгүйг авсан байна. (b) Энэ Дүрмийн дагуу нислэгийн шалгалт өгөх этгээд нь: (1) өөрийгөө нотлох баримт бичгийг биедээ авч явах;</p>	<p>63.15. Шалгалт (a) Энэ дүрмийн дагуу бичгийн шалгалт өгөх аливаа этгээд нь: 1/ биеийн байцаалтаа авчирсан байх; 2/ бичгийн шалгалтанд тэнцэхийн тулд 80-аас доошгүй хувийн үнэлгээ авсан байх. (b) Энэ дүрмийн дагуу нислэгийн шалгалт өгөх аливаа этгээд нь: 1/ биеийн байцаалтаа авчирсан байх;</p>	<p>-Шалгалтын шалгуурыг бууруулж өгсөн</p>

<p>(2) шаардлагатай сургалтад хамрагдсан тухай тэмдэглэл хийсэн нисгэгчийн дэвтэртэй;</p> <p>(3) шаардлагатай нислэгийн туршлагыг хангасан тухай тэмдэглэл хийсэн нисгэгчийн дэвтэртэй байна.</p>	<p>2/ шаардагдах сургалтанд хамрагдсан тухай тэмдэглэл бүхий болон шаардагдах нислэгийн дадлага, туршлагын тухай тэмдэглэл бүх нислэгийн дэвтэртэй байх.</p>	
<p>63.17 Шалгалтын үед хориглох зүйл</p> <p>(а) Энэ Дүрмийн дагуу шалгалтын үед, аливаа этгээд нь шалгалт авч байгаа ажилтны зөвшөөрөлгүйгээр дараах үйлдлийг хийхгүй:</p> <ol style="list-style-type: none"> (1) бусад этгээдээс хуулах; эсхүл (2) мэдээллийн эх үүсвэр ашиглах; эсхүл (3) шалгалт авч байгаа ажилтнаас бусад этгээдтэй аливаа арга замаар харьцах; эсхүл (4) бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл (5) тухайн шалгалтын материалыг авч гарах; эсхүл (6) шалгалтын бичлэгийг цахим хэлбэрээр хийх. <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан аль нэг үйлдлийг хийсэн этгээдэд дараах арга хэмжээг бүгдийг, эсхүл хэсэгчлэн авч болно:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн сэдвийн шалгалтад тэнцээгүйд тооцох; (2) өмнө нь тэнцсэн шалгалтын сэдвийг бүгдийг, эсхүл хэсэгчлэн хүчингүйд тооцох; (3) цаашид ИНД-ийн дагуу өгөх шалгалтад 12 сар хүртэлх хугацаагаар орохыг хориглох; (4) тухайн этгээдэд энэ Дүрмийн, эсхүл бусад ИНД-ийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох. 	<p>63.17. Шалгалтын үед хориглох зүйлс</p> <p>(а) Энэ дүрмийн дагуу авч буй шалгалтын үед дараах зүйлсийг хориглоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ бусдаас хуулах; эсхүл 2/ мэдээллийн ямар нэгэн эх үүсвэр ашиглах; эсхүл 3/ шалгалт авч буй хүнээс өөр хүнтэй ярих; эсхүл 4/ бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл 5/ шалгалтын материалыг гадагш авч гарах; эсхүл 6/ ямар нэг электрон хэрэгсэл ашиглан шалгалтын талаар тэмдэглэл хийх. <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан үйлдлийг гаргасан этгээдийн талаар ИНЕГ-ын дарга дараах шийдвэрийн аль нэгийг, эсхүл бүгдийг гаргана:</p> <ol style="list-style-type: none"> 1/ тухайн шалгалтад тэнцээгүйд тооцох; 2/ Иргэний нисэхийн дүрмийн хүрээнд авах аливаа шалгалтанд орох эрхийг нь 12 сар хүртэл хугацаагаар хасах; 3/ хуулийн дагуу энэ дүрмээр олгогдсон аливаа үнэмлэх, зэрэглэлийн үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох. 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.19 Нисэх инженерийн нисгэгчийн дэвтэр - Ерөнхий зүйл</p> <p>(а) Сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь нислэгийн цагийг нисгэгчийн дэвтэрт бэхээр бүртгэж хөтөлнө. Нисгэгчийн дэвтэрт оруулсан нислэгийн цаг арилсан, эсхүл устаж гэмтсэнийг зөвхөн Дарга тогтоох бөгөөд хэрэв сэргээх бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сэргээнэ.</p> <p>(б) Үнэмлэх эзэмшигч нь нислэгийн цагийн бүртгэлийг дараах хугацаанд нисгэгчийн дэвтэртээ оруулна:</p> <ol style="list-style-type: none"> (1) бүртгэгдсэн байх шаардлагатай нислэг дууссанаас хойш 14 хоногийн дотор; эсхүл (2) хэрэв үнэмлэх эзэмшигч нь үндсэн байрлалаас хол нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа бол, 	<p>63.19. Нислэгийн дэвтэр - Ерөнхий зүйл</p> <p>(а) Сурагч-нисэх инженер, нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн үнэмлэх эзэмшигч нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн нислэгийн дэвтэрт нислэгийн цагаа арилдаггүй балаар тэмдэглэнэ. Дэвтэрт тэмдэглэсэн нислэгийн цаг арилсан буюу бүдгэрсэн тохиолдолд нислэгийн цагийг нь ИНЕГ-аас сэргээн баталгаажуулна.</p> <p>(б) Нислэгийг гүйцэтгэж дууссанаас хойш, нислэгийн мэдээллийг 7 хоногийн дотор нислэгийн дэвтэрт заавал тэмдэглэнэ. Хэрэв үнэмлэх эзэмшигч нь нислэгийн дэвтрээ хадгалдаг газраас өөр газар байгаа бол буцаж ирээд 2 хоногийн дотор мэдээллийг нислэгийн дэвтэртээ оруулна.</p>	<p>-7 хоногийг 14 болгож нэмэгдсэн</p>

<p>үндсэн байрлалдаа буцаж ирснээс хойш 2 хоногийн дотор.</p> <p>(c) Үнэмлэх эзэмшигч нь нисгэгчийн дэвтрийг, сүүлчийн нислэгийн цагийг бүртгэсэн өдрөөс хойш <u>12 сараас доошгүй хугацаагаар хадгална.</u></p> <p>(d) Үнэмлэх эзэмшигч нь, нисгэгчийн дэвтэрт шаардлагатай <u>үзлэг шалгалт</u> хийлгэх зорилгоор <u>Даргад</u> хүргүүлэхийн өмнө дараах үүрэгтэй:</p> <p>(1) хуудас бүрд оруулсан мэдээллийг <u>багана тус бүрээр</u> нэгтгэх;</p> <p>(2) тухайн зориулагдсан зайднийт ниссэн цагийг тэмдэглэх;</p> <p>(3) хамгийн сүүлд оруулсан мэдээллийн төгсгөлд дээр оруулсан мэдээллүүд нь үнэн зөв болохыг баталгаажуулах;</p> <p>(4) <u>гарын үсэг зурах.</u></p> <p>(e) Энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаагүй байх үедээ агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэж байгаа этгээд нь, тухайн нислэгийн цагийг <u>туршлага хуримтлуулах</u> аль ч зорилгоор тооцохгүй.</p>	<p>(в) Үнэмлэх эзэмшигч нь нислэгийн дэвтрийг сүүлийн нислэгийн цагийг тэмдэглэсэн өдрөөс хойш наад зах нь <u>12 сарын хугацаанд</u> хадгална.</p> <p>(г) Үнэмлэх эзэмшигч нь нислэгийн дэвтэрт шаардлагатай үзлэг хийлгэх зорилгоор <u>ИНЕГ-ын даргад</u> ирүүлэхээс өмнө дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ нислэгийн цагийг хуудас бүр дээр нэгтгэн <u>дүгнэсэн</u> байх;</p> <p>2/ нислэг үйлдсэн нийт цагийг <u>зориулалтын</u> зайд тэмдэглэсэн байх;</p> <p>3/ сүүлчийн тэмдэглэлийн дор тухайн тэмдэглэл нь үнэн зөв болохыг батлан гарын үсэг зурсан байна.</p> <p>(д) Агаарын хөлөгт нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэсэн этгээд нь энэ дүрмийн холбогдох шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн цагийг нь нислэгийн цагт тооцохгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.21 Нисэх инженерийн нисгэгчийн дэвтэрт нислэгийн цаг тооцох</p> <p>(a) Хүчинтэй сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь, тухайн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн маягийн гэрчилгээ нь нисэх инженертэй байхыг шаардсан бол тухайн нислэгийн цагийг үнэмлэх, эсхүл зэрэглэл авахад тооцож болно.</p> <p>(b) Хүчинтэй сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь, багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтан дор, нисэх инженерийн ажлын байрнаас нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн цагийг нийт нислэгийн цагт <u>оруулан</u> тооцох эрхтэй.</p> <p>(c) Хүчинтэй нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь, нисэх инженерийн, багш-нисэх инженерийн, эсхүл шалгагч-нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн цагийг нийт нислэгийн цагт оруулан тооцох эрхтэй.</p> <p>(d) <u>Хүчинтэй нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь, нисэх инженер, багш-нисэх инженер, эсхүл шалгагч-нисэх инженерээс бусад, нисэх багийн гишүүнээр томилогдсон бөгөөд инженерийн ажлын байрнаас нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн бол, тухайн цагийг нийт нислэгийн цагтаа</u></p>	<p>63.21. Нислэгийн дэвтэрт - нислэгийн цагийг тооцох</p> <p>(a) Сурагч-нисэх инженер, эсхүл нисэх инженер, эсхүл нисэн хянагчийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигчийн нислэг үйлдэх агаарын хөлгийн маягийн гэрчилгээнд нисэх инженер, эсхүл нисэн хянагч нисэх шаардлагатай гэж тусгагдсан бол нислэгт үүрэг гүйцэтгэсэн цагийг тухайн үнэмлэх, зэрэглэлийн нислэгийн цагт тооцно.</p> <p>(б) Сурагч-нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч нисэх инженерийн ажлын байрнаас багш-нисэх инженерийн зэрэглэлтэй шууд хяналтанд нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийг нийт нислэгийн цагт тооцно.</p> <p>(в) Хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигчийн нисэх инженер, эсхүл нисэн хянагч, эсхүл багшлах, шалгах үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийг нь нийт нислэгийн цагт тооцно.</p>	<p>-63.21 (d) нэмж оруулсан</p>

63.23 Эрүүл мэндийн шаардлага

- (a) Энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нисэх инженерийн, эсхүл нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхийн эрхийг хэрэгжүүлэхгүй:
- (1) ИНД-67-гийн дагуу олгосон [1-р ангиллын](#) хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;
 - (2) тухайн ЭМГ-ний бүх эрүүл мэндийн баталгаажуулсан тэмдэглэлийн шаардлагыг хангасан байх.

63.25 Хоёр жилийн нислэгийн дүгнэлт

- (a) Энэ Дүрмийн дагуу олгосон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь 63.153(6)-д шаардсан нислэгийн шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жилээс дээш хугацаа өнгөрсөн бол, хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг өмнө үргэлжилсэн 2 жилийн дотор, амжилттай хийлгэсэн тухай энэ зүйлийн (c)-д шаардсан хэлбэрээр тухайн эзэмшигчийн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулсан тэмдэглэл хийснээс бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхгүй.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг багш-нисэх инженерийн зэрэглэлтэй этгээд хийх бөгөөд тухайн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ:
- (1) өмнө үргэлжилсэн 2 жилийн хугацаанд хийгдсэн холбогдох өөрчлөлтөд онцгой анхаарал хандуулан тухайн нисэх инженерийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхэд хамааралтай хүчинтэй үйл ажиллагааны ерөнхий дүрмээр шалгасан дүгнэлт;
 - (2) тухайн нисэх инженерийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхэд хамааралтай журам болон [чиг үүргийг гүйцэтгэх чадварыг](#) үнэлэх нислэгийн зааварчилгаа. Тухайн зааварчилгаанд нислэгийн [симуляторыг](#) бүхэлд нь эсхүл хэсэгчлэн ашиглаж болно.
- (c) Шалгагч-нисэх инженерийг хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг амжилттай хийлгэсэн гэж үзвэл, тухайн багш нь нисэх инженерийн нисгэгчийн дэвтэрт өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар болон гарын үсэг, хоёр жилийн нислэгийн

63.23. Эрүүл мэндийн шаардлага

- (a) Энэ дүрмийн дагуу олгогдсон сурагч-нисэх инженер, эсхүл нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч, эсхүл **нисэн хянагч** нь дор дурьдсанаас бусад тохиолдолд үнэмлэхээр олгогдсон эрх эдлэхгүй:
- 1/ ИНД-67-д заасны дагуу олгогдсон **2 дугаар ангиллын** эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна;
 - 2/ эрүүл мэндийн гэрчилгээний бүх нэмэлт шаардлагыг хангасан байна.
- (б) Үнэмлэх эзэмшигч нь өөрийн эрүүл мэндийн байдал муудсан тохиолдолд үнэмлэхээр олгогдох эрхээ эдлэхээс татгалзах ёстой.**

63.25. Хоёр жил тутмын нислэгийн үзлэг

- (a) Энэ дүрмийн дагуу олгогдсон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь 63.153 (6)-д заасан нислэгийн шалгалтыг өгсөн өдрөөс хойш хоёр жилийн дотор 2 жил тутмын нислэгийн үзлэгт хамрагдах ба тухайн үзлэгийг хангалтгүй өгсөн, эсхүл үзлэгийн үр дүнг энэ зүйлийн (в)-д заасны дагуу нислэгийн дэвтэртээ тэмдэглүүлээгүй бол үнэмлэхэнд заасан эрхийг эдлэхгүй.
- (б) Энэ зүйлийн (a)-д заасан 2 жил тутмын нислэгийн үзлэгийг шалгагч-нисэх инженер зэрэглэлтэй этгээд авах бөгөөд үзлэг дараах зүйлсээс бүрдэнэ:
- 1/ нисэх инженерийн үнэмлэхэнд ашиглагдах хүчин төгөлдөр ерөнхий үйл ажиллагааны дүрмийн талаарх үзлэг (мөрдөж буй дүрэмд өмнөх 2 жилийн хугацаанд хийгдсэн өөрчлөлтүүдийн талаар онцгойлон анхаарах);
 - 2/ нисэх инженерийн үнэмлэхэнд ашиглагдах журам болон даалгаврын нислэгийн зааварчилгааны үзлэг. Тухайн зааварчилгыг өгөхөд нислэгийн [дадлагажуур](#) бүтэн болон хэсэгчлэн ашиглаж болно.
- (в) Шалгагч-нисэх инженер 2 жил тутмын нислэгийн үзлэгийг амжилттай өгсөнд тооцвол өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон дараах тэмдэглэлийг нисэх инженерийн нислэгийн дэвтэрт хийнэ:

-Amend.1-ээр өөрчлөгдсөн

-Орчуулга, найруулга зассан

<p>дүгнэлт хийсэн огноог бичиж, дараах мэдэгдлийг оруулна: [.....Нисэх инженерийн овог нэр.....] нь ИНД-63-ын шаардлагын дагуу Хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг амжилттай хийлгэсэн болохыг тодорхойлж байна.</p> <p>(d) Энэ Дүрмийн дагуу олгосон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь энэ зүйлийн шаардлагыг хангаагүй бол, сурагч-нисэх инженерийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлж болно.</p>	<p>[.....овогтой.....] нь хоёр жил тутмын нислэгийн шалгалтыг ИНД-63-т заасан шаардлагад нийцүүлэн амжилттай өгснийг гэрчилж байна.</p> <p>..... /гарын үсэг/ ... он ... сар ... өдөр</p> <p>(г) Энэ дүрмийн дагуу олгогдсон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь энэ дүрэмд заасан шаардлагыг хангаагүй бол сурагч нисэх инженерийн үнэмлэхэнд заасан эрхийг эдэлж болно.</p>	
<p>63.27 Ур чадварын шалгалт</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь Даргын шаардсан болон тогтоож болох хугацаанд эзэмшиж байгаа үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хүрээнд ур чадвараа харуулах шалгалт, эсхүл тест өгнө.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу Даргын шаардсан шалгалт, эсхүл тест нь Даргын тодорхойлж болох, энэ Дүрмээр шаардсан шалгалт, эсхүл тестийн хэсэг, эсхүл хэсгүүдээс бүрдэнэ.</p> <p>(c) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шалгалт, эсхүл тест өгсөн боловч тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангаагүй этгээд нь үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>	<p>63.27. Ур чадварын хадгалалтын шалгалт</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь ИНЕГ-ын дарга шаардсан тохиолдолд, эсхүл ИНЕГ-ын даргын тогтоосон хугацаанд ур чадварын хадгалалтаа тогтоолгох үүднээс үзлэг, шалгалтанд хамрагдана.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан аливаа үзлэг, шалгалт нь ИНЕГ-ын даргын тодорхойлсон үзлэг, шалгалтын хэсэг, эсхүл хэсгүүд байж болно.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан үзлэг, шалгалтанд хамрагдсан этгээд шаардлага хангахгүй нь тогтоогдвол тухайн үнэмлэх, зэрэглэлээр олгогдох эрх эдлэхгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.29 Согтууруулах ундаа, эсхүл <u>эмийн бодистой</u> холбоотой гэмт хэрэг</p> <p>Согтууруулах ундаа, эсхүл <u>эмийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох</u> хуулийн дагуух тест өгөхөөс татгалзсан үйлдлийг багтаасан, согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой шүүхийн шийтгэл нь тухайн этгээдийг үнэмлэх <u>эзэмшихэд тохирох зөв хүн хэвээр байгаа эсэхийг дахин тогтоох үндэслэл болно.</u> Тухайн шийтгэл нь үнэмлэх олгохоос татгалзах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоход нөлөөлж болно.</p>	<p>63.29. Үнэмлэх эзэмшигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>(a) Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн, түүнчлэн тухайн төрлийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох үзлэгт орохоос татгалзсан этгээдийн үнэмлэх, зэрэглэл эзэмших эрхийг түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.</p>	<p>-“Мансууруулах бодис” гэснийг “эмийн бодис” гэж өөрчлөгдсөн</p>
<p>В Бүлэг - Сурагч-нисэх инженерийн үнэмлэх</p>	<p>Б БҮЛЭГ. СУРАГЧ-НИСЭХ ИНЖЕНЕРИЙН ҮНЭМЛЭХ</p>	
<p>63.51 Хамрах хүрээ</p> <p>Энэ Бүлэг нь сурагч-нисэх инженерийн үнэмлэх олгоход тавих зохицуулалтын шаардлага болон тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалтыг тогтооно.</p>	<p>63.51. Зорилго</p> <p>(a) Энэ бүлгээр сурагч нисэх инженерийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон эрх, хязгаарлалтуудыг тодорхойлоход оршино.</p>	
<p>63.53 Нөхцөл хангах шаардлага</p> <p>Сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) 18 нас хүрсэн байх;</p>	<p>63.53. Үнэмлэх авахад тавигдах шаардлага</p> <p>(a) Сурагч-нисэх инженерийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ 18 нас хүрсэн байх;</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>(2) ИНД-67-гийн дагуу олгосон <u>1-р</u> ангиллын хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх.</p>	<p>2/ ИНД-67-гийн дагуу <u>2</u> дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшсэн байх.</p>	
<p>63.55 Эрх, хязгаарлалт Сурагч-нисэх инженерийн үнэмлэх нь, дараах дадлага туршлага олж авах зорилгоор хүчинтэй багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтан дор нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх эрх олгоно: (1) нисэх инженерийн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгох <u>шаардлага хангах</u>; эсхүл (2) нисэх инженерийн үнэмлэхний <u>хүчинтэй байдлыг</u> сэргээх.</p>	<p>63.55. Эрх, хязгаарлалт (а) Сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь дараах зорилгоор нисэх инженерийн үүргийг багш-нисэх инженерийн шууд хяналтанд гүйцэтгэнэ: 1/ нисэх инженерийн үнэмлэх эсхүл зэрэглэл авах; эсхүл 2/ нисэх инженерийн үнэмлэхний <u>эрх</u> сэргээх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>С Бүлэг - Нөөц</p>	<p>В БҮЛЭГ. НӨӨЦ</p>	
<p>Д Бүлэг - Нисэх инженерийн үнэмлэх</p>	<p>Г БҮЛЭГ. НИСЭХ ИНЖЕНЕРИЙН ҮНЭМЛЭХ</p>	
<p>63.151 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь нисэх инженерийн үнэмлэх олгоход тавих <u>зохицуулалтын</u> шаардлага болон тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалтыг тогтооно.</p>	<p>63.151. Зорилго (а) Энэ бүлгээр нисэх инженерийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон эрх, хязгаарлалтуудыг тодорхойлоход оршино.</p>	
<p>63.153 Нөхцөл хангах шаардлага Нисэх инженерийн үнэмлэх эзэмших <u>этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна: (1) хүчинтэй, сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшдэг байх; (2) <u>21</u> нас хүрсэн байх; (3) нийт 100-гаас доошгүй цаг нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн байх; нийт цагийн 50-иас доошгүй цаг нь нислэгийн цаг байх; нийт цагийн 50 хүртэлх цагийг дараах байгууллагын зохион байгуулсан нисэх инженерийн сургалтын курсийн үед нислэгийн <u>симулятор</u> дээр гүйцэтгэсэн байж болно: (i) агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн, маягийн гэрчилгээнд нь нисэх инженертэй байхыг шаардсан бол; эсхүл (ii) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, <u>хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалт зохион байгуулах эрх олгодог бол; эсхүл</u> (iii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, <u>хэрэв гэрчилгээ нь</u></p>	<p>63.153. Үнэмлэх авахад тавигдах шаардлага (а) Нисэх инженерийн үнэмлэх авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна: 1/ сурагч нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/ <u>18</u> нас хүрсэн байх; 3/ нисэх инженерийн үүргийг нийт 100-аас доошгүй цаг гүйцэтгэсэн байх; үүний 50-иас доошгүй цаг нь нислэгийн цаг байх бөгөөд 50 хүртэлх цагийг дараах сургалтанд хамрагдан нислэгийн <u>дадлагажуур</u> дээр гүйцэтгэсэн байж болно: 3.1 агаарын хөлгийн маягийн гэрчилгээнд нисэх инженер нисэх шаардлагатай агаарын хөлөгт, агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс зохион байгуулсан сургалт; эсхүл 3.2 ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээврийн үйл ажиллагааны гэрчилгээ эзэмшигчээс зохион байгуулсан сургалт; эсхүл 3.3 ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалт;</p>	<p>-“18 нас” гэснийг “21 нас” гэж өөрчлөгдсөн</p>

эзэмшигчид тухайн сургалт зохион байгуулах эрх олгодог бол;

- (4) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшдэг байх;
- (5) нисэх инженерийн үүрэгтэй холбоотой бичгийн шалгалт, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх шалгалтыг дараах сэдвийн хүрээнд амжилттай өгсөн байх:
- (i) Нисэхийн хууль дүрэм: нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид хамаарах дүрэм журам; нисэх инженерийн үүрэгт хамааралтай, иргэний агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааны зохицуулалтын дүрэм, журам;
- (ii) Нислэгийн онол болон нислэгийн үйл ажиллагаа: аэродинамикийн үндэс; агаарын хөлгийн удирдлага, нислэгийн үзүүлэлт болон хүчин чадалд ачаалалт болон жингийн хуваарилалтын үзүүлэх нөлөө; жин ба төвлөрөлтийн тооцоолт; аяллын үеийн журмыг багтаасан нислэгийн үзүүлэлтийн өгөгдлийг ашиглах болон практик хэрэглээ; техник үйлчилгээний зарчим, нислэгт тэнцэх чадварыг хадгалах техник үйлчилгээний журам, гэмтлийг мэдээлэх, нислэгийн өмнөх үзлэг, түлшний сумалгааны өмнөх урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам болон газрын тэжээл хэрэглэх; суурилагдсан төхөөрөмж болон бүхээгийн систем; хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам; ачаа болон аюултай бараа тээвэрлэх үйл ажиллагааны журам;
- (iii) Агаарын хөлгийн инженеринг: хүчний төхөөрөмж, хийн турбинт болон поршинт хөдөлгүүрийн зарчим; түлшний удирдлагыг багтаасан түлшний үзүүлэлт болон түлшний систем; тослох материал ба тосолгооны систем; агаарын оролт болон шаталтын дараах систем, хөдөлгүүрийн очлуурын болон асаалтын системийн функц, үйл ажиллагаа; агаарын хөлгийн хүчний төхөөрөмжийн ажиллах зарчим болон техник үйлчилгээний журам, ашиглалтын хязгаарлалт; хөдөлгүүрийн хүчин чадалд атмосферийн нөхцөлийн үзүүлэх нөлөөлөл; агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, нислэгийн удирдлага, бүтэц, хөл анги, тормоз ба гулгалтын эсрэг төхөөрөмж, зэврэлт болон металлын ядаргаа; бүтцийн эвдрэл гэмтлийг тодорхойлох; мөстөлт, борооноос хамгаалах систем; бүхээгийн битүүмжлэл ба агааржуулалтын систем,

4/ нислэгийн радио-холбооны операторын зэрэглэлтэй байх;

5/ нисэх инженерийн үүрэгт хамаарах дараах сэдвүүдийг хамарсан бичгийн шалгалт эсхүл

5.1 нисэхийн хууль ТОГТООМЖ: нисэх инженерийн үүрэгт хамаарах дүрэм журмын мэдлэг; иргэний агаарын хөлгийн үйл ажиллагааг зохицуулсан нисэх инженерийн үүрэгт хамаарах дүрэм, журмын мэдлэг;

5.2 нислэгийн онол болон нислэгийн үйл ажиллагаа: аэродинамикийн үндэс, агаарын хөлөгт жин ба ачааллын үзүүлэх нөлөө, нислэгийн үзүүлэлт ба шинж чанар, жин ба төвлөрөлтийн тооцоо, чиг шулуун нислэгийн журмыг багтаасан нислэгийн гүйцэтгэлийн өгөгдөхүүнийг ашиглах; техник үйлчилгээний зарчим; нислэгт тэнцэх чадварын хадгалалтын журам; аливаа гэмтэл, дутагдлыг мэдээлэх журам; нислэгийн өмнөх үзлэг; түлшний сумалгаа хийх ба гадны цахилгаан тэжээл хэрэглэхээс өмнөх урьдчилсан анхааруулга; бүхээгийн системүүд болон суурилагдсан тоног төхөөрөмж; хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын журмууд; ачаа тээш болон аюултай ачаа тээвэрлэх журам.

5.3 агаарын хөлгийн инженеринг: хөдөлгүүрийн зарчим, хийн турбинт болон поршинт хөдөлгүүр; шатахууны үзүүлэлтүүд, түлшний систем, тослох материал ба тослогооны системүүд, шаталтын дараах ба тоосруулан цацах систем, хөдөлгүүрийн очлуурын болон асаалтын систем, хөдөлгүүрт хийгдэх техник үйлчилгээний журмууд, ашиглалтын хязгаарлалт ба үйл ажиллагааны зарчим, хөдөлгүүрийн хүчин чадалд хүрээлэн байгаа орчны үзүүлэх нөлөөлөл, агаарын хөлгийн их бие, нислэгийн удирдлага түүний бүтэц, хөл анги, дугуйн эд ангиуд, тормос ба гулгалтын эсрэг төхөөрөмж, зэврэлт, элэгдлийн хугацаа; их биед гарсан эвдрэл, гэмтлүүдийг тодорхойлох, мөсдөлт, борооноос хамгаалах системүүд; бүхээгийн битүүмжлэл ба агааржуулалтын систем, хүчилтөрөгчийн системүүд; шингэний болон агаарын системүүд, цахилгааны онол, хувьсах болон тогтмол гүйдлийн системүүд, агаарын

-Орчуулга,
найруулга зассан

хүчилтөрөгчийн систем; шингэний болон пневматик систем; цахилгааны онол, хувьсах болон тогтмол гүйдлийн систем, агаарын хөлгийн цахилгаан сүлжээний систем, статик холболт болон тусгаарлалт; хэрэглэл, компас, автопилот, радио болон радиолокаторын навигацийн төхөөрөмж, нислэгийн удирдлагын (flight management) систем, дэлгэц ба авионик тоноглолын ажиллах зарчим; холбогдох агаарын хөлгийн хязгаарлалт; галаас хамгаалах, гал илрүүлэх, галын идэвхжил бууруулах болон унтраах систем; холбогдох агаарын хөлгийн төхөөрөмж, системийн ашиглалт болон ажиллагааг шалгах;

(iv) Хүний хүчин зүйл: нисэх инженерт хамааралтай хүний чадвар болон хязгаарлалт;

(6) нисэх инженерийн үүрэгтэй холбоотой дараах журмыг чадварлагаар гүйцэтгэх ур чадвараа шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчид Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн шалгалтаар амжилттай шалгуулсан байх:

(i) хэвийн нөхцөлийн журам: нислэгийн өмнөх үзлэг, түлшээр сумлах журам, түлшний удирдлага; техник үйлчилгээний бичиг баримтын үзлэг шалгалт; нислэгийн бүх шатны нислэгийн бүхээгийн хэвийн ажиллагааны журам; багийн гишүүн үүрэг гүйцэтгэх чадвараа алдсан үеийн багийн харилцан ажиллагааны зохицуулалт болон журам; гэмтлийг мэдээлэх;

(ii) хэвийн бус нөхцөлийн болон нөөц журам: агаарын хөлгийн системийн хэвийн бус ажиллагааг таньж тогтоох, холбогдох хэвийн бус болон нөөц журмыг хэрэглэх;

(iii) онцгой нөхцөлийн журам: онцгой нөхцөлийг таньж тогтоох; холбогдох онцгой нөхцөлийн журмыг хэрэглэх;

(7) энэ зүйлийн (6)-д шаардсан, нислэгийн шалгалтын үед дараах чадвараа шалгуулсан байх:

(i) тухайн агаарын хөлгийн хүчин чадал болон хязгаарлалтын хүрээнд агаарын хөлгийн системийг ашиглах;

(ii) нөхцөл байдлыг зөв тодорхойлох болон нисгэгчийн ур чадвар;

(iii) нисэхийн мэдлэгээ ашиглах;

(iv) багийн нэгдмэл гишүүний хувьд, бүх ажил үүргээ, үр дүн

хөлгийн цахилгаан сүлжээний системүүд, тэдгээрийн холболт, агаарын хөлөг дэх хэрэглэл, луужин, агаарын хөлгийн автомат удирдлага, радио холбооны тоног төхөөрөмжүүд, радиолокаторын болон навигацийн тоног төхөөрөмжүүд, нислэгийн удирдлагын компьютер программын (flight management) системүүд, дэлгэцүүд ба хэрэглэлүүдийн ажлын зарчим; агаарын хөлгийн ашиглалтын хязгаарлалтууд; гал илрүүлэх, галаас хамгаалах, гал унтраах системүүд; агаарын хөлгийн тоног төхөөрөмж, системүүдийн ашиглалт, ажиллагааг шалгах.

5.4 хүний хүчин зүйл: нисэх инженерийн үүрэгт хамаарах хүний боломж ба хязгаарлалт.

5.5 радиохолбоо барих журам болон хэвшмэл хэллэг ашиглах.

6/ нисэх инженерийн үүрэгтэй хамаарах дараах журмуудыг зохих түвшинд гүйцэтгэх ур чадвараа шалгагч - нисэх инженерт шалгуулж, ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх:

6.1 хэвийн нөхцөлд баримтлах журам: нислэгийн өмнөх үзлэг, сумалгаа хийх журам, түлш, шатахууны зохицуулалт, техник үйлчилгээний бичиг баримтанд үзлэг хийх, нислэгийн бүх шатанд нислэгийн бүхээгт баримтлах хэвийн ажиллагааны журмууд, нисэх багийн аль нэг гишүүн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд багийн гишүүдийн үүргийн хувиарлалт, ажлын уялдааг зохицуулах, аливаа гэмтлийг мэдээлэх.

6.2 хэвийн бус болон нөөц журам: агаарын хөлгийн системийн хэвийн бус үйл ажиллагааг тодорхойлох, хэвийн бус болон нөөц журмыг хэрэглэх.

6.3 онцгой тохиолдлын журам: онцгой тохиолдлын нөхцлүүдийг тодорхойлох, онцгой тохиолдлын журмыг хэрэглэх.

7/ энэ зүйлийн 6/-д заасан нислэгийн шалгалтын үед дараах ур чадвараа харуулсан байх:

7.1 агаарын хөлгийн хүчин чадал болон хязгаарлалтын агаарын хөлгийн системийг ашиглах чадвар;

7.2 нөхцөл байдалд бодитой үнэлгээ өгч, зөв шийдвэр гаргах чадвар;

7.3 аэронавтикийн мэдлэгээ ашиглах чадвар;

-Орхигдуулсан

<p>(v) <u>нь амжилттай гэдэгт эргэлзэхгүй байхаар гүйцэтгэх</u>; нисэх багийн бусад гишүүдтэй <u>үр дүнтэй</u> харилцан ажиллах.</p>	<p>7.4 багийн бусад гишүүдтэй харилцан ажиллах чадвар.</p>	
<p>63.155 Эрх Нисэх инженерийн үнэмлэх нь тухайн эзэмшигчид дараах эрхийг <u>олгоно</u>: (1) сурагч-нисэх инженерийн <u>үнэмлэхний аль ч эрхийг</u> хэрэгжүүлэх; (2) тухайн маягийн зэрэглэл эзэмшдэг агаарын хөлөгт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх.</p>	<p>63.155. Эрх, үүрэг (a) Нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч дараах эрхийг <u>эдлэнэ</u>: 1/ сурагч-нисэх инженерийн эдлэх аливаа эрх; 2/ тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй бол нисэх инженерийн үүрэг гүйцэтгэх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.157 Туршлага хадгалах шаардлага (a) Нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь өмнө <u>үргэлжилсэн</u> 90 хоногт нисэх инженерийн үүргийг гүйцэтгэж байхдаа дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, нисэх инженерийн үнэмлэхний эрхийг аливаа маягийн агаарын хөлөгт хэрэгжүүлэхгүй: (1) нийт 10-аас доошгүй цагтай байх ба үүний 5 хүртэлх цагийг нислэгийн <u>симулятор</u> дээр гүйцэтгэсэн байх; (2) тухайн маягийн агаарын хөлгөөр 2-оос доошгүй удаа нислэг үйлдсэн байх; (b) Энэ Дүрмийн дагуу олгосон нисэх инженерийн үнэмлэхний эрхийг 5 жил, эсхүл түүнээс дээш хугацаагаар <u>хэрэгжүүлээгүй</u> тохиолдолд, үнэмлэх эзэмшигч нь тухайн үнэмлэхний эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 63.153(б)-д шаардсан нислэгийн шалгалт өгч тэнцсэн байна.</p>	<p>63.157. Нислэгийн дадлага туршлагад тавигдах шаардлага (a) Нисэх инженерийн үнэмлэх эзэмшигч нь өмнөх 90 хоногт нь дараах шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд аливаа маягийн агаарын хөлөгт тухайн үнэмлэхэнд заасан эрхийг эдлэхгүй: 1/ <u>нисэх инженерийн үүргийг</u> нийт 10-аас доошгүй цаг гүйцэтгэсэн байх ба үүний 5 хүртэлх цагийг нислэгийн <u>дадлагажуур</u> дээр гүйцэтгэсэн байж болно; 2/ тухайн маягийн агаарын хөлгөөр 2-оос доошгүй удаа нислэг үйлдсэн байх. (б) Энэ дүрмийн дагуу олгогдсон нисэх инженерийн үнэмлэхэд заасан эрхийг 5 буюу түүнээс дээш жилийн хугацаагаар <u>эдлээгүй</u> тохиолдолд уг үнэмлэх эзэмшигч нь 63.153-ын б/-д заасан нислэгийн шалгалтыг өгнө.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>Е Бүлэг — Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл</p>	<p>Д БҮЛЭГ. НИСЛЭГИЙН РАДИО-ХОЛБООНЫ ОПЕРАТОРЫН ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>63.201 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход тавих <u>зохицуулалтын</u> шаардлага болон тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг тогтооно.</p>	<p>63.201. Зорилго (a) Энэ бүлгээр нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход <u>тавигдах</u> шаардлага болон эрх, хязгаарлалтуудыг тодорхойлоход оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.203 Нөхцөл хангах шаардлага Энэ Дүрмийн дагуу олгох нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл <u>эзэмших этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй: (1) хүчинтэй, сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшдэг байх; (2) нисэхийн радио-холбооны практик болон журмын бичгийн шалгалтад, эсхүл <u>Даргын</u> хүлээн</p>	<p>63.203. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна: 1/ сурагч нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/ нислэгийн радио-холбооны ашиглалт, журмуудыг хамарсан бичгийн шалгалт эсхүл <u>ИНЕГ-ын</u> дарга хүлээн зөвшөөрөх</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>зөвшөөрөхүйц, дүйцэх шалгалтад <u>тэнцсэн</u> байх;</p> <p>(3) багш-нисэх инженерийн, эсхүл багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчид дараах чадвараа шалгуулсан байх:</p> <p>(i) <u>нисэхийн</u> радио-холбооны <u>дамжуулагч</u>-хүлээн авагчийн удирдлагыг зөв тохируулан ажиллуулах;</p> <p>(ii) <u>яриан</u> мэдээллийг <u>Монгол Улсын AIR-д хэвлэн нийтэлсэн журмын дагуу</u> чадварлаг дамжуулах болон хүлээн авах чадвар.</p>	<p>түүнтэй тэнцэхүйц шалгалтыг <u>амжилттай</u> өгсөн байх:</p> <p>3/ багш-нисэх инженер эсхүл багш нисгэгчид дараах ур чадвараа харуулсан байх:</p> <p>3.1 радио-холбоо хүлээн авагчийг ашиглах, тохируулах;</p> <p>3.2 аман мэдээллийг чадварлагаар хүлээн авах, дамжуулах.</p>	
<p>63.205 Зэрэглэл олгох</p> <p>(a) Багш-нисэх инженерийн зэрэглэл, эсхүл багш- нисгэгчийн зэрэглэл <u>эзэмшигч нь</u> 63.203–д заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэлийн шаардлага хангагдсан гэж үзвэл, тухайн багш нь зэрэглэл олгож, нисэх инженерийн нисгэгчийн дэвтэрт өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг, зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулна:</p> <p><i>[Нисэх инженерийн овог нэр] нь нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход тавих ИНД-63-ын шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.</i></p> <p>(b) Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшигч нь <u>Даргад</u> хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, тухайн зэрэглэлээ <u>сурагч-нисэх инженерийн</u>, эсхүл нисэх инженерийн үнэмлэхэндээ баталгаажуулсан тэмдэглэл хийлгэж болно.</p>	<p>63.205. Зэрэглэл олгох</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагчийг</u> энэ дүрмийн 63.203–д заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэлийн шаардлагыг хангасан гэж үзвэл багш- нисэх инженер эсхүл багш нисгэгч нь өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон дараах тодорхойлолтыг нислэгийн дэвтэрт нь тэмдэглэнэ:</p> <p><i>[..... овогтой.....] нь ИНД-63-т заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход тавигдах шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.</i></p> <p><i>..... /гарын үсэг/</i></p> <p><i>... он ... сар ... өдөр</i></p> <p>(б) Өргөдөл болон төлбөрийн баримтыг <u>ИНЕГ-ын</u> дарга хүлээн авснаар нислэгийн радио-холбооны <u>операторын</u> зэрэглэлээ үнэмлэхэндээ тэмдэглүүлж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.207 Эрх, хязгаарлалт</p> <p>Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл нь түүнийг эзэмшигчид, радио холбоо барих журмын дагуу нислэгийн үйлчилгээнд хуваарилсан давтамж дээр ажилладаг агаарын хөлгийн радио-холбоо, нисэхийн холбооны станц, эсхүл газрын хөдөлгөөнт станцын дараах дамжуулагч дээр ажиллах эрх олгоно:</p> <p>(1) зөвхөн энгийн гадна удирдлага хэрэглэхийг шаарддаг;</p> <p>(2) цацаж байгаа долгионыхоо давтамжийн тогтвортой байдлыг автоматаар барьдаг.</p>	<p>63.207. Эрх, хязгаарлалт</p> <p>(a) Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшигч нь нислэгийн үйлчилгээнд хуваарилсан давтамжууд дээр ажилладаг, дор дурьдсан ажиллагаатай, аливаа агаарын хөлгийн радио-холбоо, холбооны станц, эсхүл газрын хөдөлгөөнт станци дээр ажиллах эрхтэй. Үүнд:</p> <p>1/ энгийн, гадна удирдлага хэрэглэдэг;</p> <p>2/ цацаж байгаа долгионоо автоматаар тогтвортой барьдаг.</p>	
<p>F Бүлэг - Агаарын хөлгийн маягийн зэрэглэл</p>	<p>E БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН МАЯГИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>63.251 Хамрах хүрээ</p> <p>Энэ Бүлэг нь нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих <u>зохицуулалтын</u> шаардлага болон тухайн зэрэглэлийн</p>	<p>63.251. Зорилго</p> <p>(a) Энэ бүлгээр нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавигдах шаардлага болон эрхийг</p>	

<p>эрх, хязгаарлалтыг тогтооно.</p> <p>63.253 Нөхцөл хангах шаардлага</p> <p>Агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмших <u>этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> (1) хүчинтэй, нисэх инженерийн үнэмлэх эзэмшдэг байх; (2) тухайн маягийн агаарын хөлгөөр сурагч-нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн 8-аас доошгүй нислэгийн цагтай байх; (3) дараах байгууллагаас зохион байгуулсан, тухайн агаарын хөлгийн нисэх инженерийн маягийн зэрэглэлийн сургалтын курсийг амжилттай дүүргэж, агаарын хөлгийн системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам, мөн тухайн агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлт, жин төвлөрөлтийг багтаасан бичгийн шалгалтад <u>тэнцсэн</u> байх: <ol style="list-style-type: none"> (i) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн; эсхүл (ii) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол, эсхүл (iii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол, (4) тухайн зэрэглэл шаардлагатай агаарын хөлгийн маягт тохирох хэвийн, хэвийн бус, онцгой нөхцөлийн журмыг чадварлагаар гүйцэтгэх ур чадвараа багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчид шалгуулсан байна. Хэвийн бус болон онцгой <u>нөхцөлийн</u> журмыг гүйцэтгэхэд нислэгийн <u>симулятор</u> ашиглаж болно. 	<p>тодорхойлоход оршино.</p> <p>63.253. Зэрэглэл авахад тавигдах шаардлага</p> <p>(а) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ нисэх инженерийн <u>хүчин төгөлдөр</u> үнэмлэх эзэмшсэн байх; 2/ тухайн маягийн агаарын хөлгөөр сурагч нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн 8-аас доошгүй нислэгийн цагтай байх; 3/ агаарын хөлгийн үзүүлэлт, жин, төвлөрөлт, агаарын хөлгийн системийн хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн үйл ажиллагааны журмыг багтаасан бичгийн шалгалтыг өгөн тухайн агаарын хөлгийн нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгохтой холбогдсон дараах сургалтуудын аль нэгд <u>амжилттай хамрагдан</u> байх: <ol style="list-style-type: none"> 3.1 агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс <u>зохион байгуулсан сургалт</u>; эсхүл 3.2 ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчээс зохион байгуулсан сургалт; 3.3 ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалт; 4/ маягийн зэрэглэл авах тухайн агаарын хөлгийн хувьд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын журмуудыг чадварлагаар гүйцэтгэх ур чадвараа багш-нисэх инженерт харуулсан байна. Хэвийн бус болон онцгой <u>тохиолдлын</u> журмыг гүйцэтгэхэд нислэгийн <u>дадлагажуур</u>ыг ашиглаж болно. 	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>63.255 Зэрэглэл олгох</p> <p>(а) Багш–нисэх инженерийн зэрэглэл <u>эзэмшигчийг</u> ИНД-63.253-т заасан нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл авахад тавих шаардлага хангасан гэж үзвэл, тухайн багш нь нисэх инженерийн нисгэгчийн дэвтэрт агаарын хөлгийн маяг, өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон зэрэглэл олгосон огноо зэргийг бичиж, дараах мэдэгдлийг оруулна: [.....Нисэх инженерийн овог нэр.....] нь нисэх инженерийн</p>	<p>63.255. Зэрэглэл олгох</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагчийг</u> энэ дүрмийн 63.253–д заасан нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шаардлагыг хангасан гэж үзвэл багш - нисэх инженер нь өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон дараах тодорхойлолтыг нислэгийн дэвтэрт нь тэмдэглэнэ: [..... овогтой] нь ИНД-63-т заасан нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавигдах шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих ИНД-63-ын шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.</p> <p>(b) Нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшигч нь Даргад хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, тухайн зэрэглэлээ нисэх инженерийн үнэмлэхэндээ баталгаажуулсан тэмдэглэл хийлгэж болно.</p>	<p>..... /гарын үсэг/ ... он ... сар ... өдөр</p> <p>(б) Өргөдөл болон төлбөрийн баримтыг ИНЕГ-ын дарга хүлээн авснаар нислэгийн инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэлээ үнэмлэхэндээ тэмдэглүүлж болно.</p>	
<p>63.257 Эрх <u>Нисэх инженерийн</u> агаарын хөлгийн маягийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид, нисэх инженерийн үнэмлэхний эрхийг дараах агаарын хөлөгт <u>хэрэгжүүлэх</u> эрхийг олгоно:</p> <p>(1) тухайн зэрэглэлд хамаарах агаарын хөлгийн маяг дээр; <u>эсхүл</u></p> <p>(2) <u>нислэгийн үзүүлэлт</u>, систем, эсхүл журмын зарчмын зөрүүгүй тухайн маягийн агаарын хөлгийн <u>вариант дээр</u>.</p>	<p>63.257. Эрх (a) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшигч нь дараах агаарын хөлгийн хувьд үүрэг <u>гүйцэтгэх</u> эрхтэй:</p> <p>1/ тухайн зэрэглэлд хамаарах маягийн агаарын хөлөг;</p> <p>2/ <u>хүчин чадал</u>, систем, эсхүл мөрдөх журмуудын хувьд ижил бусад маягийн агаарын хөлөг.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>Г Бүлэг — Багш-нисэх инженерийн зэрэглэл</p>	<p>Ж БҮЛЭГ. БАГШ НИСЭХ ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>63.301 Хамрах хүрээ <u>Энэ Бүлэг нь багш-нисэх инженерийн зэрэглэл олгоход тавих зохицуулалтын шаардлага болон тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг тогтооно.</u></p>		<p>-Орхигдуулсан</p>
<p>63.303 Нөхцөл хангах шаардлага Багш-нисэх инженерийн зэрэглэл <u>эзэмших этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) хүчинтэй, нисэх инженерийн үнэмлэх <u>эзэмшдэг</u> байх;</p> <p>(2) нисэх инженерийн үүрэг гүйцэтгэж, 700-гаас доошгүй нислэгийн <u>цаг хүримтлүүлсэн</u> байх;</p> <p>(3) онолын болон дадлагын зааварчилгаа өгөх сургалтын <u>курсийг амжилттай дүүргэсэн</u> байх;</p> <p>(4) шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчид, нислэгийн бүх үеийн хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн талаар нисэх инженерт зааварчилгаа өгөх ур чадвараа, <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц аман болон нислэгийн шалгалтыг амжилттай өгч шалгуулсан байх. Нислэгийн шалгалтыг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг нислэгийн <u>симулятор</u> дээр гүйцэтгэж болно.</p>	<p>63.303. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) Багш-нисэх инженерийн зэрэглэл авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;</p> <p>2/ 700-аас доошгүй нислэгийн цагт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн байх;</p> <p>3/ зааварчилгаа өгөх онолын болон практик <u>сургалтад хамрагдсан</u> байх;</p> <p>4/ хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчилгыг өгөх ур чадварыг багтаасан <u>ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн аман болон нислэгийн шалгалтыг нисэх инженер-шалгагчид өгсөн байх.</u> Нислэгийн шалгалтыг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг нислэгийн <u>дадлагажуур</u> дээр гүйцэтгэж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>63.305 Эрх, хязгаарлалт (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:</p> <p>(1) тухайн нисэх инженерийн үнэмлэхний бүх эрхийг <u>хэрэгжүүлэх</u>;</p> <p>(2) сурагч-нисэх инженерийн, нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид техникийн болон нислэгийн зааварчилгаа</p>	<p>63.305. Эрх, хязгаарлалт (a) Энэ зүйлийн (б)-гийн хүрээнд багш-нисэх инженер нь дараах эрхийг эдэлнэ:</p> <p>1/ нисэх инженерийн үнэмлэхэнд заасан бүх эрх;</p> <p>2/ сурагч-нисэх инженерийн үнэмлэх болон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид техникийн болон нислэгийн зааварчилгаа</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>өгөх;</p> <p>(3) сурагч-нисэх инженерийн, нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нислэгийн симуляторт зааварчилгаа өгөх;</p> <p>(4) нисэх инженерийн үүрэг гүйцэтгэж байгаа сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид хяналт тавих;</p> <p>(5) сурагч-нисэх инженер болон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нислэгийн радио-холбооны зэрэглэлийн үнэлгээ хийж, зэрэглэл олгох;</p> <p>(6) нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн үнэлгээ хийж, зэрэглэл олгох;</p> <p>(7) нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид хоёр жилийн нислэгийн дүгнэлт хийх.</p> <p>(b) Багш-нисэх инженерийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх тухайн эзэмшигч нь:</p> <p>(1) ашиглагдах агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй хүчинтэй, нисэх инженерийн үнэмлэх эзэмшдэг байна;</p> <p>(2) тухайн эрхийг дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад хэрэгжүүлнэ:</p> <p>(i) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид нисэх инженерийн сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх эрх олгодог бол; эсхүл</p> <p>(ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид нисэх инженерийн сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх эрх олгодог бол;</p> <p>(3) өмнө үргэлжилсэн 13 сарын дотор шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигчид, бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн нислэгийн үед нисэх инженерийн зааварчилгаа өгөх ур чадвараа аман шалгалтаар болон тухайн зэрэглэлийн эрхийг бодит байдалд хэрэгжүүлэх нислэгийн шалгалтаар шалгуулна. Тухайн нислэгийн шалгалтад бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсэгт нислэгийн симулятор ашиглаж болно.</p>	<p>өгөх;</p> <p>3/ сурагч-нисэх инженерийн үнэмлэх болон нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нислэгийн дадлагажуур дээр зааварчилгаа өгөх;</p> <p>4/ нисэх инженерийн үүрэг гүйцэтгэж буй сурагч-нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид хяналт тавих;</p> <p>5/ сурагч-нисэх инженерийн үнэмлэх, нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нислэгийн радио-холбооны зэрэглэлийн үнэлгээ өгч, олгоно;</p> <p>6/ нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид нисэх инженерийн агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн үнэлгээ өгч олгоно;</p> <p>7/ нисэх инженерийн үнэмлэх эзэмшигчид 2 жил тутмын нислэгийн үзлэг хийх.</p> <p>(б) Багш-нисэх инженерийн зэрэглэлээр олгогдох эрхийг дараах нөхцөлд эдэлнэ:</p> <p>1/ тухайн ашиглагдах агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;</p> <p>2/ дээрх эрхийг дараах байгууллагын үйл ажиллагаанд эдлэхийн тулд:</p> <p>2.1 ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ нь нисэх инженерийн сургалт явуулах, үнэлгээ өгөх эрх олгосон бол; эсхүл</p> <p>2.2 ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ нь нисэх инженерийн сургалт явуулах, үнэлгээ өгөх эрх олгосон бол; эсхүл</p> <p>2.3 өмнөх 13 сарын хугацаанд уг зэрэглэлийн эрхийн хүрээнд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчилгыг өгөх ур чадварыг багтаасан аман болон нислэгийн шалгалтыг шалгах-нислэгийн инженерт өгсөн байх. Нислэгийн шалгалтыг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэж болно.</p>	
<p>Н Бүлэг — Шалгагч-нисэх инженерийн зэрэглэл</p>	<p>3 БҮЛЭГ. ШАЛГАХ-НИСЭХ ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>63.351 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь шалгагч-нисэх инженерийн зэрэглэл олгоход тавих зохицуулалтын шаардлага болон тухайн зэрэглэлийн эрх,</p>		<p>-Орхигдуулсан</p>

хязгаарлалтыг тогтооно.

63.353 Нөхцөл хангах шаардлага

Шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) хүчинтэй, багш-нисэх инженерийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (2) нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн 1250-иас доошгүй нислэгийн цагтай байх;
- (3) багш-нисэх инженерийн эрхийг хэрэгжүүлсэн нийт 750-иас доошгүй цагтай байх, үүний 250-иас доошгүй цаг нь нислэгийн цаг байх ба 500 хүртэлх цаг нь нислэгийн симулятор дээр гүйцэтгэсэн байж болно;
- (4) шалгагч-нисэх инженерийн үүргийг чадварлагаар гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын нислэгийн шалгагчид шалгуулсан байх.

63.355 Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, шалгагч-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:

- (1) багш-нисэх инженерийн зэрэглэлийн бүх эрхийг хэрэгжүүлэх;
- (2) нисэх инженерийн үнэмлэх олгох нислэгийн шалгалт авах;
- (3) багш-нисэх инженерийн зэрэглэл олгох, эсхүл түүний хүчинтэй байдлыг хадгалах нислэгийн шалгалт авах.

(b) Шалгагч-нисэх инженерийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх эзэмшигч нь:

- (1) ашиглагдах агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй хүчинтэй, нисэх инженерийн үнэмлэх эзэмшдэг байна;
- (2) ИНЕГ-ын нислэгийн шалгагчид өмнө үргэлжилсэн 13 сарын дотор шалгагч-нисэх инженерийн үүргийг чадварлагаар гүйцэтгэх ур чадвараа шалгуулсан байх ба дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад нислэгийн шалгалт авна:
 - (i) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид нисэх инженерийн сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх эрх олгодог бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид нисэх инженерийн сургалт зохион байгуулах, үнэлгээ хийх эрх олгодог бол;

63.353.Зэрэглэл авахад тавигдах шаардлага

(a) Шалгах-нисэх инженерийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ багш-нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшсэн байх;
- 2/ 1250-иас доошгүй нислэгийн цагт нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн байх;
- 3/ 750-иас доошгүй нислэгийн цагт багш-нисэх инженерийн үүрэг гүйцэтгэсэн байх, үүний нийт цагийн 250-иас доошгүй нь нислэгийн цаг байх ба 500 хүртэлх цаг нь нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн байж болно;
- 4/ шалгах-нисэх инженерийн үүргийг гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын байцаагчид шалгуулсан байх.

63.355. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (б)-гийн хүрээнд, шалгах-нисэх инженерийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхийг эдэлнэ:

- 1/ багш-нисэх инженерийн зэрэглэлд заасан бүх эрх;
- 2/ нисэх инженерийн үнэмлэх олгох нислэгийн шалгалт авах;
- 3/ багш-нисэх инженерийн зэрэглэл олгох эсхүл түүний хүчинтэй хугацааг сунгахтай холбогдсон нислэгийн шалгалт авах.

(б) Багш-нисэх инженерийн зэрэглэлээр олгогдох эрхийг дараах нөхцөлд эдэлнэ:

- 1/ тухайн ашиглагдах агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй нисэх инженерийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;
- 2/ дээрх эрхийг дараах байгууллагын үйл ажиллагаанд эдлэхийн тулд:
 - 2.1 ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь нисэх инженерийн сургалт явуулах, үнэлгээ өгөх эрх олгосон бол; эсхүл
 - 2.2 ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ нь нисэх инженерийн сургалт явуулах, үнэлгээ өгөх эрх олгосон бол; эсхүл
- 3/ өмнөх 13 сарын хугацаанд шалгах-нисэх инженерийн үүргийг гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын байцаагчид шалгуулсан байх.

-Орчуулга,
найруулга зассан

-Орчуулга,
найруулга зассан

И БҮЛЭГ. НИСЭН ХЯНАГЧИЙН ҮНЭМЛЭХ

-Зохиомол

	<p>63.401.Зорилго (a) Энэ бүлгээр нисэн хянагчийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон эрх, хязгаарлалтуудыг тодорхойлоход оршино.</p>	
	<p>63.403. Үнэмлэх авахад тавигдах шаардлага (a) Нисэн хянагчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ 18 нас хүрсэн байх; 2/ Монгол (англи) хэл дээр унших, бичих, ярих, ойлгох чадвартай байх; 3/ ИНД-67-гийн дагуу 2 дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшсэн байх; 4/ энэ бүлгийн шаардлагыг хангасан байх.</p>	-Зохиомол
	<p>63.405. Онолын мэдлэгт тавигдах шаардлага (a) Нисэн хянагчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах сэдвүүдээр бичгийн шалгалт өгнө: 1/ нисэн хянагчийн үүрэгт хамаарах энэ дүрмийн заалтууд; 2/ нислэгийн үндсүүд; 3/ нислэгийн навигацийн үндсэн зарчмууд, нислэгийн төлөвлөгөө, чиг шулуун нислэгийн удирдлага; 4/ цаг уур, цаг уурын газрын зураг дээр хийх дүгнэлт, цаг уурын мэдээ, цаг уурын урьдчилсан мэдээ, цаг уурын давтамжийн товчлол, тэмдэглэл; 5/ агаарын навигацийн тоног төхөөрөмж, ерөнхий үйл ажиллагааны журам; 6/ агаарын навигацийн тоног төхөөрөмжийн тохируулга ба ашиглалт; 7/ нислэгийн навигацийн тооцоо ашиглан агаарын хөлгийн байрлал тогтоох; 8/ сансрын төхөөрөмж ашиглан агаарын хөлгийн байрлал тогтоох; 9/ радио төхөөрөмж ашиглан агаарын хөлгийн байрлал тогтоох; 10/ агаарын хөлгийн жолоодлого, газрын зураг унших, ашиглах; 11/ навигацийн таних тэмдгийн дохионуудыг унших, ашиглах; 12/ радио холбоо барих журам, хэвшмэл хэллэг; 13/ нислэгийн үйл ажиллагаан дахь хүний боломж, хязгаарлалт. (б) Шалгалтын үнэлгээ нь шалгалт өгснөөс хойш 12 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.</p>	-Зохиомол
	<p>63.407. Дадлага, туршлагад тавигдах шаардлага (a) Нисэн хянагчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн сургалт дамжааг төгссөн байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна: 1/ шөнийн нислэгт сансар огторгуйн ажиглалтаар өөрийн</p>	-Зохиомол

	<p>байрлалыг 25-аас доошгүй удаа тодорхойлсон, өдрийн нислэгт сансар огторгуй болон бусад хэрэгслийн тусламжтайгаар өөрийн байрлалыг 25-аас доошгүй удаа тодорхойлсон нислэгийн дадлага туршлагатай байх; 2/ алсын зайн 200 цагийн нислэгт оролцсоноос 30 цаг нь шөнийн нислэг байх.</p> <p>(б) Сансрын навигаци, нислэгийн навигацийн тооцоот аргачлалаар агаарын хөлгийн байрлалыг тогтоох алсын зайн нислэгийн цагийг навигацийн дадлага авсанд тооцно. Үүнийг нислэгийн дэвтэрт тэмдэглэн эрх бүхий нисэн хянагч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.</p>	
	<p>63.409. Ур чадварт тавигдах шаардлага</p> <p>(а) Нисэн хянагчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь ур чадварын дараах шалгалтыг өгнө: 1/ аюул занал, алдааг олж, залруулах; 2/ нислэгийн навигацийн тооцоогоор нислэгийг чиглүүлэн удирдах; 3/ сансрын төхөөрөмжийн тусламжтайгаар нислэгийг чиглүүлэн удирдах; 4/ радио навигацийн төхөөрөмжийн тусламжтайгаар нислэгийг чиглүүлэн удирдах.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлд заасан ур чадварын шалгалт өгөхөөс өмнө 63.403-т заасан бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байна.</p> <p>(в) Нисэн хянагчийн үнэмлэх эзэмшигч нь радиохолбооны зэрэглэлтэй байх ба Чикагогийн конвенцийн Хавсралт 1-д заасан 4 дүгээр түвшний англи хэлний шаардлагыг хангасан байна.</p>	-Зохиомол
	<p>63.411. Давтан шалгалт</p> <p>(а) Нисэн хянагчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь бичгийн буюу ур чадварын шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд дараах хугацааны дотор давтан шалгалт өгч болно: 1/ шалгалт өгсөн өдрөөс хойш 30 хоногийн дараа; 2/ хангалтгүй үнэлгээ авсан сэдвүүдээр давтан сургалтанд хамрагдсан, эсхүл сургалт хариуцсан албан тушаалтнаас давтан шалгалт өгөхөд бэлэн болсныг баталгаажуулсан гарын үсэг бүхий мэдэгдэл ирүүлсэн бол энэ зүйлийн 1/-д заасан хугацаанаас өмнө.</p>	-Зохиомол
	<p>63.413. Нисэн хянагчийн сургалт</p> <p>(а) Нисэн хянагчийн сургалт явуулахаар хүсэлт гаргагчид, зохион байгуулах сургалтын талаарх дэлгэрэнгүй танилцуулга, сургалтын хөтөлбөр, хуваарь, ашиглах тоног төхөөрөмж, хичээлийн байрны танилцуулга, багш нарын нэрс, тэдгээрийн мэргэшлийн талаарх</p>	-Зохиомол

	мэдээлэл зэргийг үндэслэн ИНЕГ-ын дарга зөвшөөрөл олгоно.	
	К БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ДИСПАТЧЕРИЙН ҮНЭМЛЭХ	-Зохиомол
	<p>63.451. Үнэмлэх авахад тавигдах шаардлага</p> <p>(а) Агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ 21 нас хүрсэн байх; 2/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагын сургалт дамжааг амжилттай төгссөн байх; 3/ монгол (англи) хэл дээр уншиж, бичиж, ярьж, ойлгох чадвартай байх; <p>(в) Өргөдөл гаргагч нь өргөдөл гаргахаас өмнөх, тасралтгүй үргэлжлэх 6 сарын хугацаанд 90-ээс доошгүй хоногт агаарын хөлгийн диспатчерийн сургалтанд хамрагдаж, агаарын хөлгийн диспатчерийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигчийн хяналтанд ажил үүрэг гүйцэтгэсэн байна.</p>	-Зохиомол
	<p>63.453. Онолын мэдлэгт тавигдах шаардлага</p> <p>(а) Өргөдөл гаргагч нь агаарын хөлгийн диспатчерийн үүрэгт ажилд хамаарах дараах сэдвүүдээр онолын мэдлэгээ амжилттай шалгуулсан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ Иргэний нисэхийн хууль дүрэм: <ol style="list-style-type: none"> 1.1. агаарын хөлгийн диспатчерт хамааралтай дүрэм, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний журмууд; 2/ Агаарын хөлгийн тухай ерөнхий мэдлэг: <ol style="list-style-type: none"> 2.1. онгоцны хөдөлгүүр, систем, хэрэглэлүүдийн ажиллах зарчим, үндсэн ойлголт; 2.2. онгоц болон хөдөлгүүрийн ашиглалтын хязгаарлалтууд; 2.3. нислэгт зөвшөөрөгдөх хамгийн цөөн тоноглолын жагсаалт /MEL/ 3/ Нислэгийн үзүүлэлтийг тооцоолох, төлөвлөлтийн журам болон ачаалалт: <ol style="list-style-type: none"> 3.1. агаарын хөлгийн ачаалалт, жингийн хуваарилалтын үзүүлэлтүүд болон нислэгийн онцлог, жин төвлөрөлтийг тооцох журам; 3.2. нислэгийн төлөвлөлт, зарцуулагдах болон үлдэгдэл түлшний тооцоо, бэлтгэл аэродром сонгох журам, нислэгийн маршрутын хяналт, нислэгийн зайг уртасгах үйл ажиллагаа; 3.3. нислэгийн төлөвлөгөөг бэлтгэж нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад мэдэгдэх; 3.4. компьютерийн тусламжтайгаар нислэгийн төлөвлөлтийг зохиох үндсэн зарчмууд. 4/ Хүний хүчин зүйл: 	-Зохиомол

4.1. агаарын хөлгийн диспатчерын үүрэг хариуцлага, удирдлагын зохицуулалтыг багтаасан хүний хүчин зүйл болон аюул, эрсдлийг тооцох журам.

5/ Цаг уур:

5.1. нисэхийн цаг уур, даралтын орны шинж чанар, шилжилт, фронтын бүтэц, цаг агаарын онцгой үзэгдлүүдийн шинж чанар, онцлог, түүний агаарын хөлгийн хөөрөлт, буулт, замын дагуух нислэгт нөлөөлөх нөлөөлөл;

5.2. нисэхийн цаг уурын бодит болон урьдчилсан мэдээг тайлж унших, үнэлэлт дүгнэлт өгөх, газрын болон өндрийн зургийн цаг уурын мэдээллийг ашиглах.

6/ Навигаци:

6.1. агаарын навигацийн зарчмууд, хэрэглэлийн нислэгийн журам;

7/ Үйл ажиллагааны журмууд:

7.1. агаарын навигацийн баримт бичгүүд, гарын авлагыг ашиглах;

7.2. энгийн болон аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагааны журам;

7.3. агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, зөрчил болон онцгой тохиолдлын үед ажиллах журам;

7.4. хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой журам;

8/ Нислэгийн зарчмууд:

8.1. агаарын хөлгийн ангилал, төрөлтэй холбоотой нислэгийн зарчмууд;

9/ Радио холбоо:

9.1. агаарын хөлөг болон газрын станцуудтай холбоо барих журам.

63.455. Дадлага туршлагад тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагч нь дараах мэргэжлээр 2-оос доошгүй жил ажилласан дадлага туршлагатай байна:

1/ агаарын тээврийн тогтмол нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүнээр, эсхүл

2/ иргэний нисэхийн салбарт болон агаарын тээврийн байгууллагад цаг уурчийн мэргэжлээр, эсхүл

3/ нислэгийн удирдагчаар; эсхүл

4/ агаарын хөлгийн диспатчерийн туслахаар.

(б) Өргөдөл гаргагч нь зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад сургалтад хамрагдаж амжилттай дүн үзүүлсэн байх ба өргөдөл гаргахын өмнөх 6 сарын хугацаанд, ажлын 90-ээс доошгүй хоногт агаарын хөлгийн диспатчерийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч эрх бүхий этгээдийн хяналтан дор дадлагажсан байна.

63.457. Ур чадварт тавигдах шаардлага

-Зохиомол

-Зохиомол

	<p>(а) Өргөдөл гаргагч нь дараах ур чадвараа харуулсан байна: 1/ өдөр тутмын цаг агаарын мэдээ, зурагт дүн шинжилгээ хийх; 2/ нислэгийн замын дагуу ажиглагдах цаг агаарын зонхилох үзэгдэл, нөхцөл байдлын талаар зөвлөмж өгөх; 3/ нисэн очих болон бэлтгэл аэродромуудын цаг агаарын урьдчилсан мэдээнд дүгнэлт хийх; 4/ өгөгдсөн сектор дахь нислэгийн үе шатуудыг оновчтой тодорхойлох; 5/ цаг агаарын таагүй нөхцөлд нислэгийн үйл ажиллагаанд бусад шаардлагатай туслалцааг үзүүлж чаддаг байх; 6/ алдааг залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чаддаг байх.</p> <p>(б) Үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэхэнд заасан эрхийг 3 болон түүнээс дээш жилийн хугацаагаар эдлээгүй тохиолдолд давтан сургалтад хамрагдаж амжилттай төгссөн байх ба энэ дүрмийн 63.453-т заасан сэдвүүдийг багтаасан шалгалтыг амжилттай өгсөн байна.</p> <p>(в) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (б)-д заасан шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд тухайн шалгалтын үнэлгээ нь шалгалт өгсөн өдрөөс хойш хуанлийн 24 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.</p>	
	<p>63.459. Эрх, хязгаарлалт (а) Үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн дагуу олгогдсон агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэхний хүрээнд зааснаас бусад аливаа эрхийг эдлэхгүй.</p>	-Зохиомол
	<p>Л БҮЛЭГ. БАГШ НИСЭН ХЯНАГЧИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	-Зохиомол
	<p>63.501. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (а) Багш нисэн хянагчийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл бүхий нисэн хянагчийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшсэн байх; 2/ 700-аас доошгүй цагт нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэсэн байх; 3/ багшлах онол, практикийн сургалтанд хамрагдсан байх; 4/ хэвийн, хэвийн бус, онцгой байдлын нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчлагыг зохих түвшинд өгөх ур чадвараа шалгах-нисэн хянагчид харуулж, ИНЕГ-ын даргын баталсан аман болон нислэгийн шалгалтыг өгсөн байх. Нислэгийн шалгалтыг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэж болно.</p>	-Зохиомол
	<p>63.503. Эрх, хязгаарлалт (а) Энэ зүйлийн (б)-гийн хүрээнд багш-нисэн хянагч нь дараах</p>	-Зохиомол

	<p>эрхийг эдэлнэ: 1/ нисэн хянагчийн үнэмлэхэнд заасан бүх эрх; 2/ нисэн хянагчаар бэлтгэгдэж байгаа аливаа этгээдэд багшлах; 3/ нисэн хянагчаар бэлтгэгдэж байгаа аливаа этгээдэд болон нисэн хянагчийн үнэмлэх эзэмшигчид нислэгийн дадлагажуур дээр багшлах; 4/ нисэн хянагчаар бэлтгэгдэж байгаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих; 5/ нисэн хянагчийн үнэмлэх эзэмшигчид зэрэглэл олгохтой холбогдсон зааварчлага өгөх.</p> <p>(б) Багш нисэн хянагчийн зэрэглэлд заасан эрхийг дараах нөхцөлд эдэлнэ: 1/ ИНД-119, эсхүл ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, нисэн хянагчийн сургалт явуулах, үнэлгээ өгөх байгууллагын үйл ажиллагааны хүрээнд; 2/ өмнөх 12 сарын хугацаанд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчлагыг зохих түвшинд өгөх ур чадвараа шалгах-нисэн хянагчид харуулж, ИНЕГ-ын даргын баталсан аман болон нислэгийн шалгалтыг өгсөн байх. Нислэгийн шалгалтыг бүхэлд нь болон түүний зарим хэсгийг нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэж болно.</p>	
	<p>М БҮЛЭГ . ШАЛГАХ-НИСЭН ХЯНАГЧИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	<p>-Зохиомол</p>
	<p>63.551. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (а) Шалгах нисэн хянагчийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ багш нисэн хянагчийн хүчин төгөлдөр зэрэглэл эзэмшсэн байх; 2/ 1250-иас доошгүй цагт нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэсэн байх; 3/ 750-иас доошгүй нислэгийн цагт багш-нисэн хянагчийн үүрэг гүйцэтгэсэн байх. Нийт цагийн 250-иас доошгүй нь нислэгийн цаг байх бөгөөд 500 хүртэлх цаг нь нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн дадлага байх. 4/ шалгах-нисэн хянагчийн үүргийг зохих түвшинд гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын эрх бүхий байцаагчид шалгуулсан байх.</p>	<p>-Зохиомол</p>
	<p>63.553. Эрх, хязгаарлалт (а) Энэ зүйлийн (б)-заалтын хүрээнд шалгах-нисэн хянагч нь дараах эрхийг эдэлнэ: 1/ багш-нисэн хянагчийн зэрэглэлд заасан бүх эрх; 2/ нисэн хянагчийн үнэмлэх олгох зорилгоор нислэгийн шалгалт</p>	<p>-Зохиомол</p>

	<p>авах; 3/ нисэн хянагчийн зэрэглэл олгох буюу түүний хүчинтэй хугацааг сунгах зорилгоор ур чадварын шалгалт авах. (б) Шалгах-нисэн хянагчийн зэрэглэлд заасан эрхийг дараах нөхцөлд эдэлнэ: 1/ ИНД-119, эсхүл ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, нисэн хянагчийн сургалт явуулах, үнэлгээ өгөх байгууллагын үйл ажиллагааны хүрээнд; 2/ өмнөх 12 сарын хугацаанд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчлагыг зохих түвшинд өгөх ур чадвараа ИНЕГ-ын эрх бүхий байцаагчид шалгуулсан байх.</p>	
	<p>Н БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ДИСПАТЧЕРТ БАГШЛАХ ЗЭРЭГЛЭЛ</p>	<p>-Зохиомол</p>
	<p>63.601. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (а) Агаарын хөлгийн диспатчерт багшлах зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ агаарын хөлгийн диспатчерийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч байх; 2/ тухайн мэргэжлээр тасралтгүй 5-аас дээш жил ажилласан байх; 3/ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагад онолын хичээлийн болон практикийн багшийн анхан шатны болон давтан сургалтад хамрагдсан байх; 4/ агаарын хөлгийн диспатчерийн шалгах зэрэглэлтэй этгээдэд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчлагыг зохих түвшинд өгөх ур чадвараа шалгуулж дүгнэлт гаргуулсан байх, аман болон бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.</p>	<p>-Зохиомол</p>
	<p>63.603. Эрх, хязгаарлалт (а) Энэ зүйлийн (б)-гийн хүрээнд агаарын хөлгийн диспатчерт багшлах зэрэглэлтэй этгээд нь дараах эрхийг эдэлнэ: 1/ агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэхэнд заасан бүх эрх; 2/ агаарын хөлгийн диспатчераар бэлтгэгдэж байгаа этгээдийг ажлын байранд нь дадлагажуулах, зааварчилгаа өгөх, хяналт тавих; 3/ агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх хүсэж өргөдөл гаргагчийн мэргэшил, мэдлэгт үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах. (б) Энэ зүйлийн (а)-д заасан эрхийг дараах нөхцөлд эдэлнэ: 1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагад давтан сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн байх;</p>	<p>-Зохиомол</p>

	2/ мэргэшил, мэдлэг, ур чадвараа ИНЕГ-ын эрх бүхий этгээдэд шалгуулж, дүгнэлт гаргуулсан байх.	
	О БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ДИСПАТЧЕРИЙН ШАЛГАХ ЗЭРЭГЛЭЛ	-Зохиомол
	63.701. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (а) Агаарын хөлгийн диспатчерийн шалгах зэрэглэл авахаар өргөдөл гаргагч этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ агаарын хөлгийн диспатчерийн багшлах зэрэглэл бүхий хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/ тухайн мэргэжлээрээ тасралтгүй 5 жил, мөн багшийн зэрэглэлтэй 2 жил ажилласан байх; 3/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагад шалгах зэрэглэлийн онол, практикийн анхан болон давтан сургалтад амжилттай хамрагдсан байх; 4/ ИНЕГ-ын эрх бүхий этгээдэд нислэг төлөвлөлт, зохицуулалтын хэвийн болон хэвийн бус үйл ажиллагаа, онцгой тохиолдлын үеийн нислэгийн нөхцлүүдэд хамаарах зааварчлагыг зохих түвшинд өгөх ур чадвараа шалгуулж, дүгнэлт гаргуулах, аман болон бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.	-Зохиомол
	63.703. Эрх, хязгаарлалт (а) Энэ зүйлийн (б)-гийн хүрээнд агаарын хөлгийн диспатчерийн шалгах зэрэглэлтэй этгээд нь дараах эрхийг эдэлнэ: 1/ агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэхэнд заасан бүх эрх; 2/ агаарын хөлгийн диспатчер болон агаарын хөлгийн диспатчерт багшлах зэрэглэлтэй этгээдийг ажлын байранд нь дадлагажуулах, зааварчилгаа өгөх, хяналт тавих; 3/ агаарын хөлгийн диспатчерийн үнэмлэх шинээр авах болон агаарын хөлгийн диспатчерт багшлах зэрэглэлтэй этгээдийн мэргэшил, мэдлэгт үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах. (б) Энэ зүйлийн (а)-д заасан эрхийг дараах нөхцөлд эдэлнэ: 1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагад давтан сургалтад амжилттай хамрагдсан байх; 2/ мэргэшил, мэдлэг, ур чадвараа ИНЕГ-ын эрх бүхий этгээдэд шалгуулж, дүгнэлт гаргуулсан байх.	-Зохиомол

Дүрмийн боловсруулалтын хэлтэс